



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/362
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Монгол солонгосын дорнын анагаах ухааны төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ СОЛОНГОСЫН ДОРНЫН
АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:

Ц. Наранчимэг
өрөөний утас: 327744
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

ҮАГ-ын аудитын менежер
Я.Самбууням
өрөөний утас: 315558
Цахим хаяг:
sambuunyamya@audit.gov.mn

ҮАГ-ын аудитор:
Ж. Болормаа
Утас: 261628
Цахим хаяг:
bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ҮАГ-ын
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хаяг:
www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

“Аяа такс аудит” ХХК Ерөнхий захирал:
Я.Аюушжав
И-мэйл: Ayaa_ayaab@yahoo.com
Утас: 99994447

Аудитор:
Ц.Хишигзаяа
Утас: 99087133
Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
2017 оны 2 дугаар сар

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх
11. Аудитаар илрүүлсэн зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөрчилгүй санал дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасаны дагуу Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд “Аяа такс аудит” ХХК гэрээний дагуу аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материалаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийг аудитын үүрэг юм.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 06-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд завсрын болон гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөн “Аяа такс аудит” ХХК-ий аудитын баг хэрэгжүүлэв./ТАБ-СТА-А-9/

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 16-нд “Аяа такс аудит” ХХК-нд ирүүлсэн байна.

“Аяа такс аудит” ХХК аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-оос 2017 оны 2 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 22-нд Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн Ерөнхий захирал Л.Жамбалжавт гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн удирдлага нь “Эрүүл мэндийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох

бүртгэлийн тухай”, “ Компаний тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “ Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлэгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ” гэж эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог тодорхойлсоны дагуу Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв үйл ажиллагаагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн үйл ажиллагааны зорилго нь Монгол, Солонгосын дорнын анагаах ухааны эмчилгээний арга барилыг хослуулан хэрэглэж, эмнэлэгийн тусламж үйлчилгээг үзүүлэх явдал юм.

1999 онд БНСУ-ын ерөнхийлөгч Ким Тэ Жүний Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу БНСУ-ын ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд Солонгос Улсын талаас 400,000 ам.доллар, Монгол Улсын талаас 200,000 ам.долларын хөрөнгө оруулж, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яам /хуучин нэрээр/ БНСУ-ын ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/-ийн хооронд 2000 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Монгол Солонгосын хамтарсан Дорно дахины анагаах ухааны төв байгуулах тухай хэлэлцээр хийгдэж уг хэлэлцээрийг үндэслэн Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2001 оны 245 тоот тушаалаар “Оргил” рашаан сувилалыг түшиглүүлэн “Монгол Солонгосын Дорнын Анагаах Ухааны Төв” /МСДАУТ/-ийг байгуулсан .

Монгол Улсын Эрүүл мэндийн Сайдын 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 267 дугаар тушаалаар тус төвийг ЭМЯ-ны харъяалалд оруулсан байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аж ахуйн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, Сангийн яамнаас батлагдсан санхүүгийн тайлангийн нэгдсэн загварыг мөрдөж байна.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

5. Материаллаг байдал:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны үндсэн үйл ажиллагааны зардлын хэмжээг материаллаг байдлын суурь болгон авч 1 хувиар сонгон 3,1 сая төгрөгөөр тогтоов. /ТАБ-СТА-А-4/, /ТАБ-СТА-В-1/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайлант материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

7. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлого 287,2 сая төгрөг, бусад орлого 12,7 сая төгрөг нийт 299,9 сая төгрөгийн орлого, үндсэн үйл ажиллагааны зардал 312,9 сая төгрөг, бусад зардал 2,3 сая төгрөг нийт 315,2 сая төгрөгийн зардалтай тайлант хугацаанд 15,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

8. Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл

ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 5 дугаар зүйлийн 5.1-д “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:

Төлөвлөлтийн үе шатанд аудитын 3 чиглэлээр 28 эрсдлийг тогтоон, түүнд тавигдах хяналтуудыг үнэлэхэд үр нөлөөтэй байгаа тул нарийвчилсан сорилын аргаар даган мөшгих сорилыг хийлээ.

Санхүүгийн аудитыг мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдлүүдийг олж тогтоов.

Үйлчлүүлэгчээс авсан тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтууд болон өөрсдийн хийсэн судалгаануудыг байгууллагын хард дискэнд хадгалав.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй бөгөөд материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Тайлант хугацаанд ХААН банкинд нээсэн 51310491341-4 дугаартай төгрөгийн дансыг Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийсэн нь "Татварын Ерөнхий хууль"-ийн 13 дугаар зүйл 13.6-д "хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол татвар төлөгч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх бүрт өөрчлөлт орсноос хойш ажлын 20 өдрийн дотор татварын албанд мэдэгдэж, бүртгэл, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэнэ", 18 дугаар зүйлийн 18.1.12-д "банкинд данс нээсэн

болон хаасан тухай татварын албанд тухай бүр мэдэгдэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ХААН банкинын 51310491341-4 дугаар төгрөгийн дансыг бүртгүүлэх

Цөс угаах зориулалттай 7.8 сая төгрөгийн түүхий эд материалыг Солонгос улсаас хувь хүний нэр дээр илгээмжээр оруулж ирж байгаа нь "Эм , эмнэлэгийн хэрэгслэлийн тухай", "Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулиуд болон Эрүүл мэндийн сайдын 2008 оны 81 дугаар тушаал " Импортын лиценц олгох тухай"журамуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Эм , эмнэлэгийн хэрэгслэлийн тухай хууль, "Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хууль, Эрүүл мэндийн сайдын 2008 оны 81 дугаар тушаал " Импортын лиценц олгох тухай"журамыг үндэслэн тусгай зөвшөөрөл авах

12.Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны санхүүгийн тайланд 2 зөвлөмж өглөө.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2015 оны санхүүгийн тайланд “ Есөнхангай аудит” ХХК-ийн аудитаар санхүүгийн зөрчилгүй гарсан байна.

17. Зөрчилгүй санал дүгнэлт:

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгуудад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, менежментийн захидал 9 хуудсыг тус тус хавсаргав.

**МОНГОЛ СОЛОНГОСЫН ДОРНЫН АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



МОНГОЛ СОЛОНГОСЫН ДОРНЫН
АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1.

Мөнгөн хөрөнгө

Асуудал 2.

Түүхий эд материал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1.

Шилэн данс

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол Солонгосын Дорнын Анагаах Ухааны Төвийн холбогдох ажилтануудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант хугацаанд ХААН банкинд нээсэн 51310491341-4 дугаартай төгрөгийн дансыг Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийсэн нь "Татварын Ерөнхий хууль"-ийн 13 дугаар зүйл 13.6-д "хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол татвар төлөгч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх бүрт өөрчлөлт орсноос хойш ажлын 20 өдрийн дотор татварын албанд мэдэгдэж, бүртгэл, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэнэ", 18 дугаар зүйлийн 18.1.12-д "банкинд данс нээсэн болон хаасан тухай татварын албанд тухай бүр мэдэгдэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлангийн үйл ажиллагааны орлого, зарлагын дүн буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж:

Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ХААН банкинын 51310491341-4 дугаар төгрөгийн дансыг бүртгүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Түүхий эд материал	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Цөс угаах зориулалттай 7.8 сая төгрөгийн түүхий эд материалыг Солонгос улсаас хувь хүний нэр дээр илгээмжээр оруулж ирж байгаа нь "Эм , эмнэлэгийн хэрэгслэлийн тухай" хууль, "Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хууль, Эрүүл мэндийн сайдын 2008 оны 81 дугаар тушаал " Импортын лиценц олгох тухай" журамуудыг зөрчсөн байна.

.

ҮАГ-ын зөвлөмж:

Эм , эмнэлэгийн хэрэгслэлийн тухай хууль, "Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хууль, Эрүүл мэндийн сайдын 2008 оны 81 дугаар тушаал " Импортын лиценц олгох тухай" журамыг үндэслэн тусгай зөвшөөрөл авах

Эрсдэлүүд:

Эм, эмнэлэгийн хэрэгслэлийн стандартын мөрдөлтөд тавих хяналтыг сулруулах, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд аюул учруулах

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Шилэн дансны тухай	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 5 дугаар зүйлийн 5.1-д “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

Байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог алдагдуулах

ҮАГ-ын зөвлөмж:

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН СТ-1А

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,252,199.31	1,832,096.75
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	500,000.00	500,000.00
1.1.6	Бараа материал	6,181,436.00	6,037,223.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,933,635.31	8,369,319.75
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	75,834,525.00	65,564,368.63
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	75,834,525.00	65,564,368.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	84,768,160.31	73,933,688.38
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	8,303,125.00	3,001,080.00
2.1.1.2	Цалингийн өглөг	7,000.10	
2.1.1.3	Татварын өр	3,059,334.56	4,978,018.09
2.1.1.4	НДШ - ийн өглөг	3,628,587.10	9,556,530.43
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,998,046.76	17,535,628.52
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	14,998,046.76	17,535,628.52
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	60,387,091.00	60,387,091.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,252,387.00	3,252,387.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	67,930,200.00	67,930,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(61,799,564.45)	(75,171,618.14)
2.3.11	Эздийн өмчийн дүн	69,770,113.55	56,398,059.86
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	84,768,160.31	73,933,688.38

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

СТ-2А

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		өмнөх оны дүн	тайлант хугацааны дүн
1	Борлуулалтын орлого / цэвэр/	280,202,702.00	287,235,948.74
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг /алдагдал/	280,202,702.00	287,235,948.74
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		12,684,223.00
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	328,283,281.00	312,864,882.13
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		2,326,293.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		70,000.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(48,080,579.00)	(15,201,003.39)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг /алдагдал/	(48,080,579.00)	(15,201,003.39)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн ашиг /алдагдал/	(48,080,579.00)	(15,201,003.39)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз /гарз/		
24	Нийт үйл ажиллагааны дүн	(48,080,579.00)	(15,201,003.39)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

АУДИТ ХЙИСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН СТ-3А /төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
1	2015 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(13,718,985.70)	117,850,692.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
3	Залруулсан үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(13,718,985.70)	117,850,692.30
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(48,080,578.75)	(48,080,578.75)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2016 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(61,799,564.45)	69,770,113.55
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				1,828,949.70	1,828,949.70
11	Залруулсан үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(59,970,614.75)	71,599,063.25
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(15,201,003.39)	(15,201,003.39)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-				-
14	Өмчид гарсан өөрчлөлт					-
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(75,171,618.14)	56,398,059.86

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	283,984,720.31	297,727,621.44
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	279,825,783.31	287,235,948.74
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		-
	Буцаан авсан албан татвар		-
	Татаас, санхүүжилтийн орлого		-
	Бусад мөнгөн орлого	4,158,937.00	10,491,672.70
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	269,567,694.00	295,635,124.00
	Ажиллагчдад төлсөн	128,496,191.00	137,002,133.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	26,820,836.00	27,500,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	59,620,274.00	64,708,089.00
	Ашиглалтын зардалд төлсөн	18,195,307.00	24,658,660.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,444,553.00	8,133,600.00
	Хүүний төлбөрт төлсөн		-
	Татварын байгууллагад төлсөн	12,170,795.00	11,800,000.00
	Даатгалын төлбөрт төлсөн		-
	Бусад мөнгөн зарлага	17,819,738.00	21,832,642.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,417,026.31	2,092,497.44
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	70,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		70,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,200,000.00	2,582,600.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,200,000.00	2,582,600.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,200,000.00)	(2,512,600.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
	Төрөл бүрийн хандив		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		-
	Төлсөн ногдол ашиг		-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	217,026.31	(420,102.56)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,035,173.00	2,252,199.31
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,252,199.31	1,832,096.75